

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “агаар хамгаалах” гэсний дараах “уур амьсгалын өөрчлөлтийн талаарх” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.21, 6 дугаар зүйлийн 6.1.2 дах заалт, 24 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэхүү хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“6.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид авто замын салбарын бүтээн байгуулалтад хөрөнгө оруулах, зам тээврийн салбарт хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инновац, үйлдвэрлэлийн аргыг нэвтрүүлэхийг төрөөс дэмжинэ.”

2 дугаар зүйл. Энэхүү хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

“33.1.26.барилга байгууламж, үйл ажиллагаанаас ялгарч болох хүлэмжийн хийн хэмжээг тогтоох,”

2 дугаар зүйл. Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дэх заалтын “бодлого” гэсний дараа, “бага нүүрстөрөгч бүхий” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 3.1.26 дугаар заалтын дугаарыг 3.1.27 гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэхүү хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулга бүхий 35.1.24 дэх заалт нэмсүгэй.

24/. Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн сан.

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлд 1 дэх хэсэгт дор дурдсан агуулга бүхий 37.7 дах заалт нэмсүгэй.

3 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлд 1 дэх хэсэгт дор дурдсан агуулга бүхий 37.7 дах заалтыг нэмсүгэй.

37.7.35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 24-т заасан мэдээллийг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

4 дүгээр зүйл. Энэхүү хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулга бүхий өгүүлбэрийг нэмсүгэй.

“Стратегийн үнэлгээг хийхдээ уур амьсгалын өнөөгийн төлөв байдал, ирээдүйн чиг хандлагын үнэлгээний өгөгдлийг ашиглана.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулга бүхий өгүүлбэрийг нэмсүгэй.

“Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийхдээ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, уур амьсгалын төсөөллийн мэдээллийг харгалзан үзнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын "хэрэгжүүлж" гэсний дараа "уур амьсгалын өөрчлөлт," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэхүү хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 7 дах хэсгийн "...эргэлтэд оруулах" гэсний дараа " газар тариалангийн салбарт хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инновац, үйлдвэрлэлийн аргыг нэвтрүүлэх" гэж, 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалтын "..... хөрсний үржил шим алдагдсан", гэсний дараа "уур амьсгалын өөрчлөлтөд сөргөөр нөлөөлсөн" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэхүү хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт дор дурдсан агуулга бүхий 59.3.6 дах заалт нэмсүгэй.

59.3.6. Уур амьсгалын өөрчлөлтийн индекс.

2 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 2 дах хэсгийн 2 дах заалтад дор дурдсан агуулга бүхий 59.2.2.4 дэх дэд заалтыг нэмсүгэй.

59.2.2.4. уур амьсгалын өөрчлөлтийн индекс.

3 дугаар зүйл. Энэхүү хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“6.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;”

2 дугаар зүйл. Энэхүү хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УУР АМЬСГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүлэмжийн хийн тооллогын журмыг шинээр батлагдсан хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 жилийн дотор боловсруулж батална.

2 дугаар зүйл. Энэхүү хуулийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ